





Бусаннамырай ОЮУН ЭРДЭНЭ

АЛСЫН ХАРАА

Таны хил хязгаарыг тэлнэ...





ӨМЧ

```
graph TD; OMCH[ӨМЧ] --> NIITIYN[НИЙТИЙН ӨМЧ]; OMCH --> HUVIYN[ХУВИЙН ӨМЧ]; NIITIYN --> TORIYN[ТӨРИЙН ӨМЧ]; NIITIYN --> ORON_NUTGIYN[ОРОН НУТГИЙН ӨМЧ]; NIITIYN --> SHASHNY[ШАШНЫ ӨМЧ]; NIITIYN --> OLON_NIITIYN[ОЛОН НИЙТИЙН ӨМЧ]; HUVIYN --> IRGENIY[ИРГЭНИЙ]; HUVIYN --> DUNDYIN[ДУНДЫН];
```

НИЙТИЙН ӨМЧ

- ТӨРИЙН ӨМЧ
- ОРОН НУТГИЙН ӨМЧ
- ШАШНЫ ӨМЧ
- ОЛОН НИЙТИЙН ӨМЧ

ХУВИЙН ӨМЧ

- ИРГЭНИЙ
- ДУНДЫН

ӨМЧИЙГ:

ЭЗЭМШИХ

АШИГЛАХ

ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ

Биет буюу эд юмс

Үл хөдлөх

/ газар, түүнээс
салгаж болохгүй
зүйл /

Хөдлөх

/ Үл хөдлөхөөс
бусад эд хөрөнгө /

Биет бус

Оюуны үнэт зүйл

Эд хөрөнгийн эрх

Патент, лиценз, барааны тэмдгийн тухай

ЗОРИЛГО

**Оюуны өмч, түүнийг
хамгаалах талаар судлах**

**Патент, лиценз, барааны
тэмдгийн тухай мэдэх**

**Барааны тэмдэг, зураасан
кодыг уншиж чаддаг болох**

**Амьдрал ахуйдаа хэрэглээ
болгох**

ЗОРИЛТ

ОЮУНЫ ӨМЧ

```
graph TD; A[ОЮУНЫ ӨМЧ] --> B[АЖ ҮЙЛДВЭРИЙН ӨМЧИД  
ХАМААРАХ БҮТЭЭЛ]; A --> C[ЗОХИОГЧИЙН ЭРХЭНД  
ХАМААРАХ БҮТЭЭЛ]; B --> D["-ШИНЭ БҮТЭЭЛ  
-БАРААНЫ ТЭМДЭГ  
-БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАР"]; C --> E["-УРАН ЗОХИОЛ  
-УРАН ЗУРАГ, УРАН БАРИМАЛ  
-ХӨГЖИМ, ЖҮЖИГ гм"];
```

АЖ ҮЙЛДВЭРИЙН ӨМЧИД
ХАМААРАХ БҮТЭЭЛ

-ШИНЭ БҮТЭЭЛ
-БАРААНЫ ТЭМДЭГ
-БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАР

ЗОХИОГЧИЙН ЭРХЭНД
ХАМААРАХ БҮТЭЭЛ

-УРАН ЗОХИОЛ
-УРАН ЗУРАГ, УРАН БАРИМАЛ
-ХӨГЖИМ, ЖҮЖИГ гм

Патент гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, зохиолч тодорхой хугацаанд түүнийг **өмчлөх эрхтэй** болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа **баримт бичгийг** хэлнэ.

Лиценз гэж патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг бусдад **ашиглуулах** зөвшөөрлийг хэлнэ.

Оюуны өмч нь лицензийн гэрээ байгуулах,
үйлдвэрлэл эрхлэх, ханган нийлүүлэх ба
тараан хуваарилах гэрээ хэлэлцээр,
нийлүүлж нэгтгэх ба худалдан авах зэрэг
худалдаа арилжааны үйл ажиллагаанд
хамгийн үнэтэй хөрөнгийн нэг буюу
хамгийн гол хөрөнгө хэмээн тооцогдож
байна.

**МОНГОЛ УЛС ДЭЛХИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН
БАЙГУУЛЛАГАД 1979 ОНД ГИШҮҮНЭЭР
ЭЛССЭН.**

Шинэ бүтээл гэж байгалийн
хуулинд тулгуурлан, анх
сэдэж, үндэслэлийг нь нээн
илрүүлсэн үйлдвэрлэх арга
ажиллагаа болон
бүтээгдэхүүнд хамаарах **цоо**
шинэ шийдлийг хэлнэ.

Бүтээгдэхүүний загвар гэж
үйлдвэрлэлийн аргаар хийх
боломжтой бүтээгдэхүүний
хэлбэр, хийцэд хамаарах
өвөрмөц **цоо шинэ шийдлийг**
хэлнэ.

Барааны тэмдэг бол тодорхой хувь хүн, үйлдвэрийн газар өөрийн үйлдвэрлэдэг бараа, үйлчилгээг бусдынхаас ялгах зорилгоор хэрэглэдэг таних тэмдэг юм.

**Барааны тэмдэг нь нэг буюу
хэд хэдэн үг, үсэг, тооны
хослол, эзэлхүүнт дүрс,
хөгжмийн болон дуу авианы
тэмдэг, үнэр, өнгөнөөс
бүрдэж болно.**




Mongolian Cashmere



Maroon | English | Русский



Бараа бүтээгдэхүүнийг таних код нь янз бүрийн зайтай, өргөн нарийн зураастай байхын зэрэгцээ 13 оронтой тооноос бүрддэг байна. Сайн ажвал голын урт зураас нь хоёр хуваагдсан байгаа. Эхний тав буюу зургаан оронтой тоо нь тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрийн нэрийг өгүүлдэг бол гол зураасаас хойшхи таван оронтой тоо нь тухайн барааны түүхий эд, нэр, зориулалт, өнгө, үнэ зэргийг тус тус заасан байдаг аж.



УЛСЫН КОД

ҮЙЛДВЭРЛЭГ
ЧИЙН КОД

БАРААНЫ КОД

ХЯНАЛТЫН
ТОО



Кодыг соронзон оронд мэдрэмтгий будгаар тавьсан байх ба дээгүүр нь скайнер бүхий багажийг гүйлгэн таньдаг байна. Харин кодын өмнө болон хойно нь хаалт байвал лицензийн бараа байна гэж ойлгож болно.



Зураасан кодын дугаараар уг бараа баталгаатай, үнэн зөв эсэхийг шалгах арга:

1. Тэгш байрлалд байгаа тоонуудыг нэмнэ. $1+3+5+7+9+1=26$
2. Гарсан нийлбэрийг 3-аар үржүүлнэ. $26 \times 3 = 78$
3. Хяналтын оронг оруулахгүйгээр сондгой байрлалд байгаа тоонуудыг нэмнэ. $0+2+4+6+8+0=20$
4. 2 ба 3-р заалтаар гарсан тоонуудаа нэмнэ. $78+20=98$
5. Гарсан хариуны хамгийн сүүлчийн нэгжийн оронг 10-аас хасна. 98-ын 8 $10-8=2$

ЭНЭ НЬ ХЯНАЛТЫН ТООНЫ СҮҮЛЧИЙН ОРОНТОЙ ТААРЧ БАЙХ ЁСТОЙ. ХЭРЭВ ӨӨР БАЙВАЛ УГ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХУУРАМЧААР ҮЙЛДСЭН БАЙНА ГЭЖ ОЙЛГОЖ БОЛНО.

Бие даах ажил:

**1-р баг. 4974019024325 -
тооны машин**

**2-р баг. 3700082500203-
үнэртэй ус**

**3-р баг. 8713016023704 –
үсний индүү**

4974019024325- тооны машин

1. $9+4+1+0+4+2=20$

2. $20 \times 3 = 60$

3. $4+7+0+9+2+3=25$

4. $60+25=85$

5. $10-5=5$

3700082500203- үнэртэй ус

1. $7+0+8+5+0+0=20$

2. $20 \times 3 = 60$

3. $3+0+0+2+0+2=7$

4. $60+7=67$

5. $10-7=3$

871301602370⁴ – үсний индүү

1. $7+3+1+0+3+0=14$

2. $14 \times 3=42$

3. $8+1+0+6+2+7=24$

4. $42+24=66$

5. $10-6=4$

13

Юуг бусдад
ашиглуулах
зөвшөөрлийг
лиценз гэх вэ?

Өмчлөх эрхийг хүлээн
зөвшөөрсөн баримт
бичиг нь лиценз үү?
Патент уу?

Аж үйлдвэрийн өмчид хамаарах
бүтээлд барааны тэмдэг
хамаарах уу? Үгүй юү?

Зохиогчийн эрхэнд хамаарах бүтээл
нь ямар өмч болох вэ?

Автомашин нь үл хөдлөх хөрөнгө үү?
Хөдлөх хөрөнгө үү?

Иргэн хүн өмчийг эзэмших,,
..... эрхтэй.

Шашны өмч ямар өмчид хамаарах вэ?

Өмчийг юу гэж хоёр хуваадаг вэ?

ГЭРИЙН ДААЛГАВАРТ:

**Ахуйн хэрэглээний 2-3
бараа бүтээгдэхүүнийг
зураасан кодын дугаараар
шалгах / дэвтэрт наах /**

**Хичээлд
идэвхтэй
оролцсонд
баярлалаа.**

Click to add text
Click to add text